

Үүлэн зардас

Сэрэмж алдсан нэгэн ягшас, хилинт эзний бошго зарлигаар Сүр жавхлангаа бууруулан, үзэсгэлэнт амрагаасаа жилээр хагацаад Сэтгэлд тааламжит гүнжийн угаалд ариудсан мөрний ойр, Сүүдэр төгөлдөр галбарварас модот Рамын уулнаа суун авай.

Амраг хонгороосоо олон сар хагацан уйдаж суусаар турж, Алтан бугуйвч царвуунд тогтохгүй, Бүрвасад сар төгсөх өдөр, Аугаа заан, соёогоор уул мөргөн наадах мэт бөхийсөн Алсын үүл, уулын оргилд налан наалдсаныг ажин үзвэй.

Эрдэнэсийн эзний дагагсад, түүнийг ширтэн, удтал зогсож, Элэг эмтрэн, нулимс барьж ядан, тэсгэлгүй гунихран уйтгарлав Энх жаргалтан ч, үүл үзээдсэтгэлд гунил төрөх атал, Энхрий янагаа тэврээсэй гэж хүсэгч зовлонтыг хэлээд яах вэ?

Зуны хоёрдугаар сар болж, амраг юугаа сэтгэл санаа амуулж, Зуураас үүлээр мэндийг мэдэгдэх ухаан бодож олоод, тэр ягшас Зулгараагүй сайхан маллига цэцгээр тахил өргөн бариад Зуучилж, амрагийн сэтгэл сэргээхийг өчин мөргөвэй.

Утаа, гэрэл, ус хийгээр бүтсэн нэгэн үүл яахин зардас болж, Учиртай уг захиаг уламжлан нэвтрүүлж чадах билээ? Уйтгар гунигт автагдсан ягшас гэдэг тэр хөөрхий, Ухаарч үүнийг бодсонгүй биз, янаг сэтгэлийн энэлгэнд.

Хормустын түшмэл үүл, дүрсээ дураараа хувьсгагч чамайг Хожим галав юүлүүлэх үүлсийн угсаатан гэж шинжин танинам Хувь зохиолдоо амрагаас хагацсан би чамайг өчин гуйнам. Хувьгүй намайг эс дагавч, доордыг гуйснаас надад тэр нь дээр.

Энэлгэтнийг тэтгэгч үүлэн чи, хайртад минь мэдээ хүргээч, Эзэн Гүвираагийн зарлигаар хагацсан намайг энд гэж хэлээч, Ягшасын эзний Алага балгасанд очиж, цэцэрлэгийн дунд Шива тэнгэрийн магнайн саран туяанд гийгч орд харшид.

Агаар тэнгэрээр халин одох чамайг Алага зорин явахад Аянчны эхнэр үсээ сөхөн харж, нөхрөө хүсэн хүлээнэм, Аянга дуугий чинь сонсоод, амрагаа таалахыг хэн үл хүсэх вэ? Азгүй би л эзний хилинд эрстэж, энхрийлэн таалж үл чадам.

Сааталгүй замнан явсаар, ажин түүнийг үзэх вий чи, Санаандаа өдөр хоног тоолон хүлээж суугаа вий, тэр минь, Цэцгийг түшигч ишийн адил, эмэгтэй хүний амрагийн сэтгэлийг Цээжинд нь горьдлын иш түшин дэмжиж, амий нь залгам заа.

Аясын зөөлөн салхин чамайг аятайхан урагшлуулж, Аялгуу сайхан дуугаар зүүн хажуунаас чинь заадага жиргэж, Агаарт халин, үрс бэлгэдэгч чамайг сайн хувьт нүдээр Аятайхан харж, эгнэн цувах тогоруу шувуу тосном заа.

Алтан дэлхийг мөөгний шүхрээр бүрхэж, үр шим дэлгэрүүлэгч Аянгат чиний дуугий чинь хун шувуу сонсон дуулаад, Алс хол Манас нуураа санан хүсэж линхувын соёогоор, Амь залгаж хойноос чинь, Хайлас уул хүртэл барааднам.

Ариун Рамын өлмийн оромж гэж хотлоор тахигч Оргил өндөр энэ уулаа салан одохдоо

тэврэн таалмуу. Он бүр чамтай учран нийлэхдээ, чамд хайртайн тулд Оргилсон халуун нулимсаа асгаруулан хайлдаг биш үү, тэр?

Чиний явах сайн замыг, үүл чамдаа зааж өгье би, Чихэнд шингээж захих үгээ дараагаар нь хэлж өгье, Алжаан ядрах цагт уулсын оргил түшин амсхийгээрэй, Ангах цангах цаг, нуур голоос ундлан шамдаарай.

Уулын үзүүр булгалж үнэр хөлөглөгч салхин одсон буюу гэж Ууль хайлан, бүтэгсдийн хатагтай нар эмээн харнам заа. Шимт нишингү ургасан бэлээс хагацаад, умрыг чиглээрэй, Шируун догшин зүгийн зааны хошуунд замдаа савардуулалгүй.

Сайхан эрдэнийн гэрэл гийгүүлсэн хормустын нуман Шоргоолжны үүрийн үзүүрээс татан гарнам заа. Вишнийн хөх үхэрчин, тогосын гялалзсан өднөөс өнгө орох мэт, Хөхрөн харагдах дүрий чинь улам үзэсгэлэн болгом заа.

Балгадын хатагтай адил, сэртэнтэхийг үл мэдэгч тариачин эмс, Баясгалант нүдээр чамайг ширтэн, үрсийг арвижуулна гэлцэнэ. Баахан хурын усаар тариаланг дэлгэрүүлээд алгуур өөд болж, Баруун зүг барьсхийн явсаар, умар зүгийг барин одоорой.

Алсын замд алжаасан чамайг, бэлийн түймэр унтраасан Ачий чинь санан өндөр Амрагуда уул оргилдоо амраана. Ачтан нөхрийн ач тусыг өчүүхэн хүмүүн үл марттал, Агулсын өндөр Амрагуда яахин чиний ачийг үл бодом.

Амрагуда уулын оргилд амран тогтохын цагт чинь Анарын жимс боловсорсон нь үзэсгэлэнт эмсийн хөхнөө адил, Үхэл үгүй эр, эм хоёрын гайхаж харахад, дэлхий эхийн Үзэмжит цагаан хөх, дундаа хөх дуслаар чимсэн !

Ойн гөрөөчний гэргий оршигч байшинт тэр уулнаа түдээд Уснаасаа хөнгөлөн асгаж, цаашлан замнахад чинь, Уруудаж Виндья уулнаа Нармадын гол мурилзах нь, Уран зураачийн будсан зааны нурууны хээ мэт амуу.

Зааны бохь анхилж, замбу модод мөргөлөн урсагч, Нармада голын сайхан уснаас сэрүүцэн сэргэж уу. Усан төгс баригч чамайг үнэр хөлөглөгч үл хөдөлгөм. Угаас хоосон юм хөнгөн, юмтай юм жинтэй байдаг!

Гаадамбын ногоон бөгөөд заримдаг шар тоорцогт цэцэг харан, Гадалийн ёсоор соёолон ургасныг балчигт газар чимхэн идэгч буга Галд түлэгдсэн газар дэлхийн үнэр аваад ус баригч чамд Гялалзсан хурдан дусалт үүлсийн тоомыг зааж өгнөм заа.

Тосч, борооны дусал уух заадага бялзуухайг үзээд, Тогорууны жигдлэн цувж нисэхийг харж, бүтэгсдийн эрс Тажигнах дуунд чинь тэвдэн тэвэрсэн гэргийтэйгээ эвцэлдээд Талархан баярлах сэтгэлээ чамд илэрхийлэм заа.

Тааж байна би: сайн мэдээ хүргэхийг яаравч, Таатай цэцэг анхилсан ууланд түдэн саатаж, Тогос шувуу баярын нулимс унаган донгодон тосоход, Түдэл үгүй хагацан салж үл чадам заа, чи

Хүрэхэд чинь, Дасарна орны цэцэрлэгийг, цагаан гядага цэцэг Хүрээлэн бүслээд, ариун модонд нь элдэв шувууны үүр дүүрээд, Замбу модны зах нь боловсорсон жимст харлан харагдаж, Заавал хэд хонох бий тэнд саатаж, хун шувуу.

Видиша хэмээн хотол алдаршсан Дасарнын нийслэлд хүрээд, Видравадийн мяралзсан долгионт уснаас үнсэн цэнгэхэд чинь, Хөмсөг зангидсан эмэгтэйн царай мэт үрчлээтэн, Хүрчигнэж эргийн захаар дуугарам тэр ус нь.

Тэндээс Низай гэдэг ууланд хүрээд алжааснаа амсхийж, Дэр нийлэхэд чинь гаадамбын цэцгээр чичрэн бүрхюү, Хадны нь хонгилоор хүүхнүүдийн хүжийн үнэр ханхалж, Хавийн завхай залуучуудыг гэрчлэн заанам.

Сэгхийгээд чанагш одохдоо, ойн голын эргийн гүнд цэцгийг Сэрүүн дуслаараа сэргээгээд, цэцэг түүгч сайхан охидыг Сэрвэгнэн савирах хөлсөө арчсаар чихний линхув чилснийг Сэрүүцүүлэн хоромхон ч гэсэн амрааж өгөөрэй.

Умрыг зүглэхдээ муруйн гажисхийгээд, Ужжайнийн орд харш лугаа Учран дайралдах завшаан тохиол замд чинь байх буй заа. Балгад түүний баясгалант эмсийн гялалзах нүдээр буландахад Бахдах сэтгэл чинь эс хөдөлвөөс харамсмаар буй заа.

Долгисон хөдлөхөд дуугарагч хун шувуу бүсэн чимэгт Нирвандья голтой тохиолдоход чинь, үелзэн үймэгч эргүүлэг нь, Үзэсгэлэнт эмсийн гүн хүйс мэт сэтгэл татан хөдөлгөх нь, Үнэн хүслээ эмэгтэйчүүд хайртандаа дохиогоор анх уламжлам.

Сайн хувьт аа, тэр гол, чамаас хагацан зүдэрсэн хатан мэт Салаалан урсах ус нь, салаа нарийн шанх адил болоод, Эргийн модноос унасан навчинд өнгө царай нь зэвхийрчээ. Энэлгий нь арилгаж, дуслаараа амилан сэргээх ёстой, чи

Удаянын түүх, гацаа хүйн өтгөс хэлэлцдэг Авандийн орноо, Урд дурдсан, эрдэнэсээр баялаг бөгөөд тэнгэрийн нэгэн хэсгийг Буяныг нимгэрэхэд, доошоо буухдаа тэнгэр нар энэ дэлхийд Буулгасан нь Ужжайнийн орд харшид хүргээрэй.

Тэнд үүрээр Шипра голын жавар нь, тогорууны дуу дуулдуулж, Дэлгэрсэн линхувын тун биенд сайн үнэр ханхлуулж ирэх нь, Тэсгэлгүй хурыцлаас алжаан ядарсан хатагтай нарыг Тэмтрэн эрхлүүлж, амраг нь дахин дур хөдөлгөх адил.

Голдоо эрдэнэ шигтгэсэн гоё сондор, тоо томшгүй сувд. Гялгар өвсөн ногоон маргад эрдэнийн чулуу, Гоё шүр, тана дэлгүүр дүүрэн тэнд дэлгээстэйг Гайхан үзэхэд, далайг шүүж, дан ус үлдээсэн мэт.

Тэнд Вадасаранза, Брадийода хааны гүнж халуун авчээ. Тэнд тэр хааны алтан дал модны ой байсан ажээ. Тэнд Налагири заан ороо орж, шонгоо сугалжээ гэж Тэр газарчин хун, зочинд сонин болгон ярих ажам.

Гэгээвчээр гарах үнэрт улагын утаанд утуулж, Гэрийн тогосын бүжгээр хүндэтгэн ёслуулаад, Хатагтайн өлмийн будаг нь цэцэг болсон орд харшит Ужжайнийг баялагт зам

зуурын алжаал сэргэн одмуу.

Гурван сансрын эзни оронд ороход өнгий чинь Эзний хоолойн адил гэж нөхдийн нь чуулган сүслэм заа. Гандарвади голын жавар усанд наадагч охидын ооны үнэр, Удвал цэцгийн үнэр ханхлуулж, үүсгэмэл цэцэглэлийг хөдөлгөм.

Их харын оронд өөр цагт хүрээд, өдөр боловч нарыг Илт жаргахын цагийг хүлээн саатаарай, үүлэн чи. Гурван үзүүртийг баригч Шивыг орой хэнгэрэг цохин танихад Луугийн дуун дуурьсаж хотол даяарт сүр бадруулаарай.

Үдэш, чуулганы үзэсгэлэнт эмс, хөл хөдөлгөн, бүсэлхийн чимгийг Үелзүүлэн хангинуулж, үзэмжит дэвүүр барьсан гар нь чилээд, Хур оруулсанд чинь, урт нүдээр буландах нь зөгий гялалзах шиг, Хурьцангуй амрагийн чимхсэнийг сэрүүцүүлсэнд баярлам заа.

Шингэх нарны гэрэлд жава цэцэг мэт час улаан болоод, Шива тэнгэрийн ойн том мод мэт мутрыг ороогоод, Зааны нойтон шир барин бүжих хүслийг нь хангахад Завсраас хатан нь хөдлөхгүй нүдээр бишрэн харам заа

Амрагтаа шөнийн харанхуйд айн очиж яваа эмст Алтаар чулуу зурсан шиг цахилгаанаар замы нь зааж, Аятайхан гийгүүлээд, аймхай тэднийг сочоож, Аянгын дуу дуурсган, хур оруулахыг тэвчээрэй, чи

Тачигнан гялалзсаар алжаасан цахилгаан гэргий лүүгээ Тагтаа унтсан байшингийн орой дээр хоноод, Наран гарахад зорчин аялах замдаа ороорой, Найртай нөхрийн тусыг бодогсод, зуур үл саатам.

Хүсэн гомдсон эмэгтэйн нулимсыг амраг нь өглөөгүүр арилгам. Хүний тэр ёс мэдэж, нар халхлалгүй замаас нь зайлаарай. Налина цэцгийн линхувын царай дахь шүүдрийн нулимсыг Нар өөрөө арилгадгийг, халхлаж түүнийг битгий хилигнүүлээрэй.

Гамбира голын сэтгэл нь тунгалаг усан мандалд Гайхамшиг сайхан чиний дүр тусан тодорном заа. Гүмүда цагаан цэцэг мэт харж, загас дээшээ үсэргэн хүндэтгэх Гол түүний хүслийг огоорон тэвчвээс үл зохим за.

Гулзалзах зэгсэн эмжээрт хөх усан хувцсыг нь сөхүүлээд, Гуя болсон хоёр эргий нь нүцэглэнхэн гаргаад, Хэвтсэн нөхөр чи, дорхиноо яаж өндийн босох вэ? Хэн нэгэнт амты нь аваад нүцгэн түүнээс салах вэ?

Дивагири хүрэх хүсэлт чамайг салхи алгуур хөдөлгөм Дэлхийн чиний хурд сэрүүцсэн сайхан үнэр авч Заан баясгаж, хамрыг нь тургиулан дуугаргагч Дэгдмэл тэр салхин, зэрлэг, удамбарын жимс болгоно.

Тэндээс чи Девагирид цэцэгт хурын үүл болж Скандад Тэнгэрийн Гангын усаар норгосон цэцгийн хур оруулмуу Тэр Сканда, Хормустын цэрэг хамгаалж, нарнаас халуун дуслаа Галайхаанд өргөсөн шинэ саран баригч Шивын үр ажам.

Уул цурайтам луугийн дуу дуурсгаж, Скандын тогосыг Уянгатайяа бүжиглүүл. Зовхинд нь Шивын алман сар туяарч, Ума, үр юүгээн энхрийлэн, хөх линхуваар чимсэн чихнээ Унасан нүдэт өдийг нь авч чимэг болгон хэрэглэх ажам.

Хулсны цэцэглэгээс төрсөн тэр тэнгэрийг тахин цаашлахад Хурын уснаас эмээгч бүтсэн эр, эм пипа барин зайлам заа. Үхрээр тахисан газар нь гол урсан дэлхийд тогтож, Үүрд Рандидэвийг алдаршуулсан түүнээ саатасхийгээрэй

Кришна тэнгэрийн өнгөт чамайг голын уснаас авахад Огторгуйгаар явагчин бүхэн дорогш харан үзвээс Урт гол, үүл чамтай алсаас хатан дэлхийн хүзүүнд Голдоо индранил эрдэнэтэй сувд эрх мэт үзэгдэм.

Тэр гол гартал, цагаан гүнדה цэцэг дээрх хар зөгий мэт, Хар ногоон ялгарсан нүдний нь харц, хөдлөн дохих Ороонго мэт хөмсгийн дороос чамайг таааланхан харах Дашабүра балгасны хатагтай нарын сэтгэл чамд тусам.

Сүүдэр хэлбэртэй болж Ариуна орогч оронд гүрүчадраагийн Хан язгууртын байлдаан хийсэн газар хүрэн бууна уу чи. Гандивын эзэн Аржуна тэнд хан язгуурт ноёдын толгой Линхуваар чиний хур буулгах адил, түмэн хурц сум буулгажээ.

Амарлингуй төгөлдөр өө, Саарасвадийн уснаа хүч хүртээд, Гаднаа хар боловч, дотроо ариудан цагаан больюу, чи Анжисчин Баларама, саднаа эрхэмлэж байлдааныг тэвчээд, түүнийг Рөвадийн нүдэн туссан үнэт дарсны оронд уусан гэдэг.

Цаст уулнаас Ганахалын тэнд бууж, сагарын үрсэд Тэнгэр өөд дэвших алхам болсон Гангад Гуручадраагаас од. Тэр мөрөн, Умын хөмсөг зангидсан царайг элэглэн, Цагаан хөөс сахарсан долгиогоор Шивын магнайн сар шүүрэм.

Мөрөн түүний уснаас уух гэж тэнгэрийн заан мэт, Огторгуйгаас хагас биеэ унжуулж, тунгалаг болор Мөрөн түүний уснаа сүүдрээ тусгахад чинь, Ямуна мөрөн лүгээ Ганга дахин нийлсэн мэт сэтгэгдэм.

Гангын эх болсон цаст цагаан уулнаа хүрвээс, Хүдэр орших хадан хясаа нь заарын үнэр анхилан, Газрын хол аянд алжааж, оргил түшин амрах чинь Гурван мэлмийт Шивын цагаан бухын онгичсон шавар мэт үзэгдэм.

Салхинд харгай мод хавиралдан ой түймэр шатаад, Сарлагийн саваг сүүл хуйхлаваас, түмэн дусал Хур юугаан буулган, галын гамшиг дараарай. Зовлонтны гасланг нимгэлэх нь дээдсийн хишиг!

Уул түүнээ найман хөлт догшин буга чамайг дайран. Замаас нь зайлбал, үе мөч нь хэмхрэн сүйрэм заа. Аянга мөндөртэй хур буулган хөөж зайлуулмуу. Хирээ мэдэхгүй дайрагсад, шоолуулахын орон буюу заа.

Магнайдаа алман сарт Шивын өлмийн ором тэнд буйг Бишрэн, эргэл мөргөл хиймүү. Бүтэгсэд йогини нар, Өлмийн ором түүнийг дахин шүтдэг үүнээ, хэн хүн Шүтэн тахиваас,

болор бат орон болох больюу.

Үнэр хөлөглөгч орсон хулснаас яруу аялгуу гараад, Гинарийн хатагтай нар хөгжмийн аялгуу нийлүүлж, Гурван балгадыг ялсны эгшиг дуун дуурсгахад, чи Хаданд хэнгэрэг адил дуугарваас Шивын хөгжим бүрдэм.

Үзүүштэй сонин газраар өнгөрөн, бие сунаасан байдлаар Бали мангасыг дарсан Вишнийн хөх өлмий төслөж, Сухг Рамын алдар бадруулж, хунгийн хаалга болсон Хавцал Грүнза давааны боомтоор умрыг чиглээрэй.

Ахин явсаар, охин тэнгэрийн толь болсон Гайласа уул хүрч, Арван гарт Раванад бэлээ ноолуулсан түүний зочин болом заа. Цагаан гүмүда мэт оргилоор огторгуй тулсан тэр үүл, Гурван мэлмийт Шивын инээдэм биелэн тогтсон мэт үзэгдэм.

Гялалзсан бараан тосон өнгөт чамайг, саяхан огтолсон Зааны соёо нь цагаан оргилд нь хүрэхийг үзэхүл, Анжисчин Баларамын цагаан мөрөнд хэдэрсэн Хөх нөмрөг адил, тогтуун ажихад сонин үзэгдэм заа.

Могойн бугуйвчит Шивын мутрын хажууд суугч Ума эхэд Цэнгэлийн уул түүнээ ажирья гэж мутраа сунгаваас. Доторхи усаа хураан тогтоогоод, Умын алхамд зохицон, Эрдэнийн бэл өөд авирах үүлэн шат болж өгөөрэй.

Тэр ууланд тэнгэрийн хатагтай нар бугуйвчийн үзүүрээр Цоо чичин усы чинь гоожуулж угаал хийх гэх бий. Салж эс өгвөл, зун цаг тул, зугаач тэр хатагтайг Чихийг нь дөжиртөл аянгын дуугаар сүрдүүлээрэй.

Айравада зааныг агшин зуур аятайхан халхлаад, Алтан тоорцогт линхувт Манас нуурын уснаас ундлан, Галбарварас модны найлзуур салхиар найгуулан ганхуулж, Гайлас уулыг зүйлийн наадмаар цэнгүүлэн баясгаарай.

Аяа дураар бидэгч чи, тэр уулын өвөрт Алага балгас гэж, Амрагийн өвөрт, Гангын усан хувцас тайлаад орсон мэт буй, Түүнийг таним заа: долоон давхар цагаан байшин нь, Үсээ сувдаар чимсэн хатагтайн адил хурын үүлээр чимээстэй.

Өнгөт зураг, үзэсгэлэнт охидтой, хэнгэрэг цохисон хөгжимтэй, Эрдэнээр өнгөлсөн асар харшийн тэр байдлыг үлгэрлэн зүйрлэвээс, Цахилгаан гилбэлгээтэй, солонготой, аянгын сүрт дуутай, Хурын устай, өндрөө явагч үүлсийн чуулгантай адилтгам ажээ.

Хатагтай нар линхув барин, үсэндээ гүн да цэцэг хатгаж, Царайн өнгө, лодрэ цэцгийн оо түрхэж цайвгар болоод, Гүрвага цэцгээр үсээ, сайхан шришаа цэцгээр чихээ чимээд, Чиний ирэхэд цэцэглэсэн гаадамбаар шанхаа гоёном заа,

Үргэлж цэцэглэгч тэндэх модыг зөгий бужигнан тойрч, Насад цэцэглэгч линхувыг хун цэн хүрээлэн эргэж, Хэзээд гялалзагч өдөт тогос донгодонхон дуугарч, Үүрд гийгч саран гэрэлд шөнийн харанхуй дарагдам.

Тэндэх ягшас гагцхүү жаргалын нулимс бөмбөрүүлэн, Гаслангүй, гагцхүү янагийг мэдэж бие, сэтгэл нийлэм. Амрагууд хэрэлдэхээс өөр хагацахыг огт үл мэдэн, Орь залуугаас өөр, өглөхийн дүрийг үл үзэм.

Тэндэх ягшас, тэнгэрийн одон гялалзан тусах үзэмжит Болор эрдэнийн сайхан тагт харшид үзэсгэлэн төгөлдөр Гоо охидын хамт галбарварсын жимсийн шим янагийн сархад Чиний дуутай адил хэнгэргийн дуу сонсон ууж жаргам.

Тэнд маш үзэсгэлэнт охид, мөрний захын мандар модны Таатай сүүдэрт, Гангын усны амьсгалт сэрүүн салхинд Алтан элснээ зэндмэнь эрдэнэ булж нуугаад, Таалцан эрж, цаг ямагт цэнгэл наадам хийнэм,

Тэнд тачаангуй амрагууд нь хувцсыг нь хуу татаж Бүсийг нь тайчихад, вямба жимс мэт улаан уруулт хүүхнүүд, Ичиж улайсандаа, гэрэлтэй эрдэнийн зул унтраах гэж Атга атгаар дэмий л оогоо сацан сацан оролдном.

Тэнд чиний адил том үүлс, салхинд хөөгдөн орж, Долоон давхар амсрын зургийг чийгтэй нойтон болгоод, Айж эмээхдээ хэрэм мөргөж хэсэг хэсэг уур болж, Цонхны торын нүдээр угаа мэт суунаглан гарам.

Шөнө дүл үүлэн завсар сарны гэрэл гэв гэгээнээ, Лавриас унжсан саран зэндмэнь тунгалаг шүүдэр дусаан, Амрагийн эвцэлдсэнийг тавихад цэнгэлийн чилээ арилгаж, Үзэсгэлэнт сайхан эмсийн биеийг сэрүүцүүлэм.

Тэнд барагдашгүй эрдэнийн сантай тачаангуй амрагууд, Вайбрэнз цэцэрлэгт тэнгэрийн дууч сайхан эмстэй, Өдөр алгасалгүй цэнгэн жаргаж, гинарис хөгжимдөн, Цэнгэл цэцэрлэгийн эзэн Гувирааг эгшиглэн магтах ажам.

Тэнд нар мандахад, янагтаа шөнө очсон эмэгтэйчүүдийн Үснээс ойчсон мандар цэцэг, чихнээс ойчсон линхувын дэлбэ, Яарч гүйхэд нь тасарч унасан сувд, хүзүүний сондор чимэг Энгэрээс нь бас тасран ойчиж, шөнийн гүйдлийг заах ажам.

Тэнд эмэгтэйчүүдийн биеийн чимэг болох бүх юм, Эрээн хувцад, нүдийг тачаангуйгаар гялалзуулах сархад, Уян шимт цэцэг, зүйл бүр хээ чимэг, линхув мэт Үзэсгэлэнт хөлийн будаг булт галба модноос гардаг байна.

Тэнд Гүвирийн нөхөр Шивын занг мэдэгч амрагийн тэнгэр Зөгий хөвчит нумаа барин ирэхээс аюун эмээвч, Алиа гоё эмс, хөмсгөө гулзгай нум, буландах нүдээ Амрагийн зүрх оногч сум болгож, цэнгэл наадам хийнэм.

Тэнд Гүвирийн ордноос умар тийш Хормустын нум болсон, Үзэсгэлэнт солонго мэт үзэмжит хаалгатай миний гэр бий. Амрагийн минь, хүү адил асран тарьж ургуулсан мандар мод нь Цэцгийн цоморлиг гараар барим доошоо унжиж байх вий.

Гэрийн дэргэд маргад эрдэнийн гишгүүртэй, захаараа Индранила эрдэнийн ишгэй алтан линхувтай цөөрөм бий. Энэлэхээс ангижирсан хун шувууны чуулган тэнд оршин, Чамайг

үзэвч, Манас сайхан нуураа үл санах вий.

Тэр цөөрмийн захад Индранила оргилтой цэнгэлийн уул, Алтан гадалийн модоор хүрээлүүлж, нөхөр, чамд үзэгдэх бий. Хаяагаараа цахилгаан гялалзуулах чамайг харахдаа адилшааж, Миний янагийн хайртай тэр уул санаанд минь орном.

Тэнд гунда цэцгийн сэхээвч, гурвага цэцгийн хүрээтэй бий. Дэргэд нь гаслангүй улаан мод, гэсрийн сайхан модон, Навч гишүү нахилзан, миний адил, амрагийн минь хөл хүрэхийг Нэг нь хүлээж, нэг нь амнаас нь балга дарс хүсэн хүлээм.

Тэр модон хооронд орой дээрээ болортой алтан багана бий. Нялх хулсны өнгөт эрдэнэ ёроолдоо шигтгээтэй тэр багананд Чиний нөхөр тогос, миний амрагийн бугуйвчаа хангинуулан Хөөрхөн алгаа ташихад бүжиглээд, үдэш нь суудаг билээ.

Аяа нөхөр, миний цээжинд байгаа энэ тэмдгээр бас Үүдэн талд нь лавай линхувын зурагтайг үзээд лав, Наран шингэхэд линхув цэцгийн өнгө буурдагтай адил, Надгүй өнчирсөн орон гэрий минь танин олох биз ээ, чи.

Хурдлан хүрэхийн учир, зааны тугалын дайтай болж. Миний дурдсан үзэмжит бэлтэй цэнгэлийн ууланд бугаад, Гялаан хурц цахилгаанаа галт хорхой гийх мэт Аятай зөөлөн болгоод, гэрт минь шагайж үзээрэй.

Янаг минь, чилгэр залуу, шүд хурц, уруул вямба улаан, Бэлхүүс нарийн, хүйс гүн, гуя зузаан, алхам алгуур, Хөх том, нүд нь цочсон янзаганы нүд мэт хөөрхөн, Эсрэн тэнгэрийн заяасан гоо хатагтайн манлай билээ.

Нөхөр надаас хагацан, ижлээс салсан уран хажин мэт, Уйдагч хоёрдугаар амь минь болсон тэр хөөрхий минь, Зовлонгийн удаан, гаслангийн уртад доройтож, Цас хяруунд өнгө буурсан линхув мэт болсон биз ээ.

Хонгорын минь царай, үүл бүрхсэн сар мэт зэвхийрч, Нүд нь уйлсаар хавдаад, гашуун шүүрс алдсаар, Хоёр уруулын өнгө нь буураад, эрүүгээ тулсан тэргүүнээ Сагсайсан үсээ самнан зассан шинж үгүй биз ээ.

Удалгүй чи түүнийг харамзаа. Эсвэл залбирч суугаа, Эсвэл, хагацан турсан намайг цээжээр зурж байгаа байх, Эсвэл тор дахь шрига бялзуухайн жиргэн донгодоход нь, Чамд хайртай нөхрийг минь, чи ер санадаг уу гэж асуудаг бизээ.

Аяа сайн нөхөр! Хирт хувцастай, өвөр дээрээ пипатай Миний нэр бэлгэдсэн хүслийн яруу эгшиг дуурсгах гээд Пипийн чавхдас нулимсанд нь чийгтээд, аялгууг таслан, Нийлүүлж олсонд аяа сэтгэл гунихран мартаж байнам заа.

Чамайг харахад, хагацан салснаас учрах хүртэл үлдсэн хоног Босгоны тэндэх цэцгээр тоолон бодож байх вий, хөөрхий Эсвэл надтай уулзаж байгаа гэж сэтгэлээ тэжээн буй заа Эмээтэй хун, хайртаасаа холдвол, тэгдэг ёс бий билээ.

Өдөр юм хийдэг тул, хагацсаны зовлон бас гайгүй, Бүрэнхий шөнийн цаг ганцаардаж байхад хэцүү вий. Шөнө нойргүй хөсөр хэвтэн зовж балхын цагт нь, Харшийн цонхоор миний мэдээ хүргэж үзээрэй, чи минь.

Сэтгэлийн зовлонд хатаж, дорно зүгээс гарагч Шинэ хавирган сар мэт агийж, орон дээрээ ганцаараа, Урд хоёулаа цэнгэлдэхэд агшин зуур өнгөрдөг шөнө, Одоо нулимс асгаруулан ганцаараа хэвтэхэд юутай урт!

Рашаан мэт сэрүүн бөгөөд цонхоор тусагч саран гэрлийг Урьдын дадлаар нэг хараад авснаа байж орхиод, Мэлтгэр нулимсанд дарагдсан сормуусаар нүдээ халхлах гэх нь Газрын линхув будант өдөр дэлгэрэх бус, хумбих бус лугаа адил.

Тосгүй угаасан чийгтэй үсээ хацарт унжихад нь, Цоморлиг мэт уруулыг дарагч халуун сүүрсээр үлээж, Зүүдэндээ ч надтай нийлэх асан гэж зүүрмэглэхэд нь, Нүднээс гоожих нулимс, зүүд нойрыг нь тасалнам заа.

Зэмийн хугацаа гүйцэхэд миний гараар задлах ёстой, Хагацах өдөр цэцгийн чимэг сугалж өөрөө сүлжсэн гэзэг нь Хүрэхэд хөндүүр, чийгтэй ширүүн болоод хацраасаа холдуулж, Хумсаа аваагүй хуруугаар тэр гэзгээ түлхнэм заа.

Эцэж турсан хөөрхий тэр минь, чимгээ тайлаад, Зовлонт бие нь орон дээрээ хэвтэж ядан байхыг, Үзэнгүүт, чи хурын нулимс асгаруулан хайлам заа. Зөөлөн сэтгэлтэн, бусдын зовлонг өрөвднөм буюу.

Эцэж турсан хөөрхий тэр минь, чимгээ тайлаад, Зовлонт бие нь орон дээрээ хэвтэж ядан байхыг, Үзэнгүүт, чи хурын нулимс асгаруулан хайлам заа. Зөөлөн сэтгэлтэн, бусдын зовлонг өрөвднөм буюу.

Тэр хөөрхийн надад нэн амраг хайртайг би мэдээд, Тиймэрхүү байдалтай болоод байгаа гэж тааж байнам. Намайг чалчаа гэж бүү бодоорой, би хувьтай амьтан шүү Миний өгүүлсэн бүгдийг удалгүй чи үзэн мэдэх болом заа.

Бодоход, гөрөөсөн нүдэт тэр эмэгтэйн нүдний буландах нь Унжсан үсэндээ хашигдаж, тос түрхэж гялалзахаа байгаад Дарсанд хөлчүүрч амрагийн санаа нэвтрүүлэхээ мартавч Чамайг харахдаа загасны хөдөлгөөн хөх линхув мэт гоо болом заа

Заяа буруугаад, сувд чимгээ тэвчиж, дэр нийлсэн хойно Миний таалан илдгээс салсан, гадилийн цагаан иш мэт Зөөлөн цагаан зүүн гуя нь, миний хумсны ор арилавч, Чичивхийлж татганан хөдлөх нь бас юуны магад.

Аяа үүл, тэр хүн нойрсон жаргах хувь тохиолдоод, Намайг тэврэн зүүдлэхэд нь, ороонго мод мэт тэврэн, Намайг хүзүүдсэн гарыг нь салган сэрээхийг тэвчиж, Аянгынхаа их дууг түр татан хүлцэж үзээрэй.

Мааладын шинэ цэцэг ханхалсны найрт салхи, Хурын дусаалаар түүнийг минь сэрүүцүүлэн сэрээгээд, Чамайг харах цонхоор нь, аянга цахилгаанаа далдлаад Луугийн хүрхрэх дуугаар

дуурсган үгээ хэлээрэй.

Хувьтай чи, бэлэвсэн бус, чиний нөхрийн сайн нөхөр үүл Чамд түүний сэтгэлийн үгийг уламжлах гэж ирснийг тань! Гэргийн сүлжсэн гээгийг нөхрөөр нь тайлуулах гэж Аянгын дуугаар аянчныг шавдагч үүл би байна гээрэй,

Тэр үг сонсоод, чиний зүг сэтгэл тэсгэлгүй яарч хараад, Үнэр хөлөглөгчийн хүүг Шита үзсэн адил, харж хүндэтгэм заа Тэгээд чамайг сонсох нь, эмэгтэй хүнд нөхрийн мэдээ Нөхрөөс нь сонсохдоо, амраг лугаа учран нийлсэнтэй бараг нэг бий.

Аяа, наснаа төгөлдөр! Бусдын тус бүтээвэл өөрийн тус бүтнэ. Миний үг сонсон дамжуулахдаа, амраг чинь Рамын ууланд Чамаас хагацан, амьд бөгөөд, чиний мэндийг асууна гээ Тэр үг хагацах зовлонд учрагсдын ам нээж асуудаг үг.

Бие алсалж, үйлс буруутсан нөхөр чинь, нарийхан, туранхай, Уйлж гансарсан, халуурсан биетэй чинь эцэж турсан, уй гашуу болсон Амьсгаадсан хөөрхий биеэрээ нийлэн учирч байгаатай адил Дотроо сэтгэн санаж суугаа гэж хайртад минь хэлээрэй.

Хажуудах хүний чинь дэргэд ил хэлж болох үгийг Хайртай нүүрий чинь шөргөөх гэж шивнэн хэлдэг тэр чинь. Чамайгаа чихээрээ сонсч, нүдээрээ үзэж чадахгүй болоод Намайг уламжилж хэлээрэй гэж эдгээр үгс найруулжээ.

Ороонго модноо чиний уяхан мөч. цочимхой согооны нүднээ Чиний нүд, сарнаа чиний янаг царай тогосын өднөө Чиний үс, мөрний долгионоо чиний хөмсөг атираах үзэгдэн, Юм бүхэнд одоо чиний төс байна гэж үздэг боллоо.

Хадан дээр баясгалант хилинт чамайг зосоор зураад, Чиний өлмийн дэргэд хэвтье гэхэд нүдний нулимс Хур мэт асгараад, нүдэн бүрхэгдэхийг хэлэх үү? Зургаар ч гэсэн, золгон нийлэхийн хувьгүйг дурдах уу?

Зүүдэндээ ч гэсэн, хайртай чамайгаа тэврэхсэн гэж Гар сарвалзан, хоосон хий тэврэх намайг ойн тэнгэрс Өрөвдөн харахдаа тэсгэлгүй уярч, сувд мэт нулимс Модны мөчир найлзуурт бөмбөртөл унаган дусаах ажам

Хималайн салхин энд тэнд харгайн салаа мөчир шовтлон, Давирхайн үнэр ханхлуулж, өмнө зүг хүрч ирэхэд нь, Үе мөчинд чинь хүрээд наашаа ирсэн болов уу? гэж Сэтгэлээ тэжээж, салхи тэвэрдэг шүү, хонгор минь!

Шөнийн барагдашгүй уртыг яагаад нэгэн агшин болгож, Өдрийн бүгчим халууныг яагаад намуун зөөлөн болгоё доо! Түргэн харцат чамаасаа хагацан гансарсан миний сэтгэлийн Аль л зовлонг тоочин хэлж тэр бүр барах вэ, би!

Ингэж бодсоор биеэ барьж, сэтгэлээ хатамжлан суунам, Хайртай чи минь, бас хэтэрхий цөхрөн зовоод яах юм бэ, Үргэлж зовох, үргэлж жаргахын ёсон байдаг үгүй Хүний өөдлөх, уруудах нь тэрэгний хүрдийн адил вий!

Вишнү, могойн орон дээрээс сэрэхийн үес эзний зарлиг төгсөнө Үлдэх тэр дөрвөн сарыг нүдээ анин хүлцэн өнгөрөө. Тэгээд, учран золгохын цаг, хагацалд хүссэн бүх хүслээ Намрын сарын гэрэлт шөнө бүрэн гүйцэд эдэлнэ гээд

Бас нэмж хэлсэн нь: Намайг хүзүүдэн тэврээд унтаж байснаа Гэнэт хашгиран сэрж билээ чи. Дахин дахин асуухад, Ай давхар санаат! Чамайг ондоо авгайтай цэнгэлээ гэж Зүүдэнд орлоо гэж мишээн хэлснээ санам уу чи?

Аяа, хар нүдэт минь, тэр зүүднийх шиг намайгаа бодоод Элдэв юм битгий сана! Хагацахад сэтгэл хөндийрнө гэж Амьтны хэлэлцдэг тэр үг түмэн худал! хагацахад Хайртай сэтгэлийн хүсэл хурсаар улам ч ихэддэг!

Анх хагацсандаа гашууддаг ч түүнийу минь тайтгаруулаад Шивын бухад онгичуулсан Гайласа уулнаас үтэр буцаж, Хайртай хүний мэндийн мэдээ надад хүргэж ирэн, Үүрийн гүнда цэцэг мэт амийу минь авран үйлд.

Аяа сайн минь! Нөхрийнхөө энэ зүйлийг гүйцэтгэлгүй дээ Чиний хариуу сонсч байж л зөвшөөрснийг мэднэ гэхгүй би Гуйгсдын хүслийг хариу хэлэхгүй гүйцэлдүүлэх ёс бий. Үг хэлэлгүй, чи загравага бялзуухайг ундалдаг шүү дээ.

Аяа үүлэн, хагацал зовлонт намайг өрөвдөх нөхөрсөн, Аль нэгэн сэтгэлээр миний өчүүхэн хүслийг гүйцэлдүүлээд, Хурын улирал ойртсоны сайхныг бадруулж ажран одохдоо, Агшин зуур ч цахилгаан хатагтай лугаа үл хагацах болтугай.